| 2109   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>112,007,600.00</b>   | <b>106,864,336.00</b>   | <b>5,143,264.00</b>   | <b>95.4</b>  |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 99,002,200.00           | 93,859,700.00           | 5,142,500.00          | 94.8         |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 13,005,400.00           | 13,004,636.00           | 764.00                | 100.0        |
| 213    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>104,139,800.00</b>   | <b>84,623,165.00</b>    | <b>19,516,635.00</b>  | <b>81.3</b>  |
| 2132   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>104,139,800.00</b>   | <b>84,623,165.00</b>    | <b>19,516,635.00</b>  | <b>81.3</b>  |

|               |  |                         |                         |                     |              |
|---------------|--|-------------------------|-------------------------|---------------------|--------------|
| 213205        | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал                 | 87,428,700.00           | 67,912,065.00           | 19,516,635.00       | 77.7         |
| 213209        | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                  | 16,711,100.00           | 16,711,100.00           | -                   | 100.0        |
|               | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                    | <b>1,664,291,622.48</b> | <b>1,661,271,499.63</b> | <b>3,039,052.00</b> | <b>98.6</b>  |
| <b>1310</b>   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                           | <b>1,497,167,200.00</b> | <b>1,497,167,200.00</b> | -                   | <b>100.0</b> |
| 131001        | Улсын төсвөөс санхүүжих                                  | 1,497,167,200.00        | 1,497,167,200.00        | -                   | 100.0        |
| <b>1320</b>   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                    | <b>135,886,222.48</b>   | <b>135,886,222.48</b>   | -                   | <b>100.0</b> |
| 132001        | Орон нутгийн төсвөөс                                     | 135,886,222.48          | 135,886,222.48          | -                   | 100.0        |
| <b>120004</b> | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>             | <b>11,796,600.00</b>    | <b>8,757,548.00</b>     | <b>3,039,052.00</b> | <b>74.2</b>  |
| 1200041       | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                | 7,536,400.00            | 1,143,748.00            | 6,392,652.00        | 15.2         |
| 1200042       | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                | 4,260,200.00            | 7,613,800.00            | (3,353,600.00)      | 178.7        |
| <b>4</b>      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>  | 19,441,600.00           | 19,460,529.15           | (18,929.15)         |              |
| <b>5</b>      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b> |                         | 142,064,044.05          | (142,064,044.05)    |              |
| <b>61</b>     | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>                                  |                         |                         | -                   |              |
| 610001        | Төсвийн байгууллага                                      | 1                       | 1                       | -                   | 100.0        |
| <b>62</b>     | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                                  | <b>60</b>               | <b>60</b>               | -                   | <b>100.0</b> |
| 620001        | Удирдах ажилтан  | 4                       | 4                       | -                   | 100.0        |
| 620002        | Гүйцэтгэх ажилтан  | 39                      | 39                      | -                   | 100.0        |
| 620003        | Үйлчлэх ажилтан  | 17                      | 17                      | -                   | 100.0        |
| <b>63</b>     | <b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>                | <b>960</b>              | <b>740</b>              | -                   | <b>77.1</b>  |
| <b>630</b>    | <b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>         | <b>960</b>              | <b>740</b>              | -                   | <b>77.1</b>  |
| 630001        | Төрийн өмчит ЕБС   | 960                     | 740                     | -                   | 77.1         |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь “Багш сурагчдын хамтын оролцоонд тулгуурлан суралцах ур чадвар арга зүйг хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багш, суралцагч, эцэг эх олон нийтийн оролцоотойгоор боловсролын шинэчилсэн хуулийг хэрэгжүүлэх.
- Цахим технологид суурилсан нэмэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэн суралцагчийн ур чадвар, багшийн арга зүйд ахиц гаргах.
- Сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэн шинжлэн судлах арга барилд сургах.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 7 дугаар сарын 7-нд шинэчлэгдэн батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд:*
  1. *“ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх”,*
  2. *“Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах” чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 123,350.2 мянган төгрөгөөр буюу 3.44 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт                                     | /мянган төгрөгөөр/ |                    |                  |
|--|--------------------|--------------------|------------------|
|  | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт         |
| Б  | 1                  | 2                  | 3=2-1            |
| Мөнгөн хөрөнгө                               | 19,460.5           | 142,064.0          | 122,603.5        |
| Авлага                                       | 1,352.9            | 1,400.2            | 47.3             |
| Бараа материал                               | 140,090.2          | 189,793.5          | 49,703.3         |
| Үндсэн хөрөнгө                               | 3,417,149.9        | 3,368,146.0        | (49,003.9)       |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>3,578,053.5</b> | <b>3,701,403.7</b> | <b>123,350.2</b> |
| Өр төлбөр                                    | 8,150.1            | 196.8              | (7,953.3)        |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 3,569,903.4        | 3,701,206.9        | 131,303.5        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>3,578,053.5</b> | <b>3,701,403.7</b> | <b>123,350.2</b> |

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 142,064.0 мянган төгрөг байгаа нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу тайлант жилийн үйл

ажиллагааны зардлын хэмнэлтийг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасантай холбоотой байна.

- Бараа материалын дансны үлдэгдэл 189,793.5 мянган төгрөг болж 49,703.3 мянган төгрөгөөр өссөн нь БШУГ-аас 4,386.1 мянган төгрөгийн ном, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 19,452.4 мянган төгрөгийн хими, физикийн кабинетын иж бүрдэл, БШУЯ-аас 1,502.7 мянган төгрөгийн зураг, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 11,519.2 мянган төгрөгийн сургалтын материалыг үнэ төлбөргүй орлого авснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,368,146.0 мянган төгрөг болж 49,003.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 42,188.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, БШУГ-аас 4,847.3 мянган төгрөгийн, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 56,382.5 мянган төгрөгийн, БШУЯ-аас 5,836.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, Сумын ИТХ-ын 2023 оны 85 дугаар тогтоолоор 83,574.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталснаас,
- Тайлант оны эцэст өглөг дансны үлдэгдэл 196.8 мянган төгрөг болж 7,953.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны цалингийн өглөгийн барагдуулснаас тус тус шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,110,731.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 135,886.2 мянган төгрөгөөр нийт зарлагыг 1,246,617.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Улсын төсвөөс 1,497,167.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 135,886.2 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 7,536.4 мянган төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 4,260.2 мянган төгрөгийг, урьд оны үлдэгдлээс 19,441.6 мянган төгрөг төвлөрүүлэхээр, төсвийг нийт 1,664,291.6 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 1,664,291.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,519,207.5 мянган төгрөгийг зарцуулж, 145,084.1 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,519,207.5 мянган төгрөг буюу 90 хувьтай байгаа нь боловсролын стандарт сургалт 105,066.5 мянган төгрөг, сургалтын хэвийн үйл ажиллагаа 13,583.7 мянган төгрөг, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 19,516.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д         | Арга хэмжээ                                 | Төлөвлөгөө         | Гүйцэтгэл          | Зөрүү            | Биелэлт   |
|-------------|---|--------------------|--------------------|------------------|-----------|
| 1           | 80226- Байр ашиглалтын үйлчилгээ            | 3,427.9            | 3,427.9            | 0.0              | 100       |
| 2           | 80312- Сургалт семинар                      | 1,714.0            | 1,714.0            | 0.0              | 100       |
| 3           | 81605- Эрүүл мэндийг дэмжих                 | 3,428.8            | 3,425.0            | 3.8              | 100       |
| 4           | 81801- Үдийн цай хөтөлбөр                   | 87,428.7           | 67,912.0           | 19,516.7         | 88        |
| 6           | 81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин       | 41,014.9           | 41,014.9           | 0.0              | 100       |
| 7           | 81823- Боловсролын багшийн сургалт          | 7,730.7            | 7,652.4            | 78.3             | 99        |
| 8           | 81827- Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр    | 90,141.2           | 85,346.9           | 4,794.3          | 98        |
| 9           | 81834- Боловсролын стандарт сургалт         | 1,102,852.6        | 997,786.1          | 105,066.5        | 89        |
| 10          | 81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа       | 177,270.0          | 163,686.3          | 13,583.7         | 92        |
| 11          | 81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн        | 8,949.5            | 6,909.3            | 2,040.2          | 77        |
| 12          | 81848-Сурах бичгийн түрээс                  | 4,296.4            | 4,296.4            | 0.0              | 100       |
| 13          | 83603-Нэмэлт Дээд шатны төсвөөс             | 150.7              | 150.0              | 0.7              | 100       |
| <b>Дүн</b>  |   | <b>1,528,405.4</b> | <b>1,383,321.2</b> | <b>145,084.2</b> | <b>91</b> |
| 14          | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 135,886.2          | 135,886.2          |                  | 100       |
| <b>Нийт</b> |   | <b>1,664,291.6</b> | <b>1,519,207.4</b> | <b>145,084.2</b> | <b>90</b> |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх 87,428.7 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй тул Ундрах тум ХХК, Алтан тариа ХХК, Цахим ертөнц ХХК, Ц.Цэсэм, Л.Өлзийсайхан, С.Энхтайван нартай шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Аав ээжийн тэнгэрлэг буян аудит” ХХК-ийн ахлах аудитор О.Чулуунбаатар, аудитор Ю.Уртнасан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал О.Бурмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,340,093.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,400.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд боловсролын байгууллагын мэдээлбэл зохих 20 төрлийн 166 мэдээллийг байршуулахаас 2 төрлийн мэдээг хоцроосон байна. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний 69,183.5 мянган төгрөгийн 7 мэдээллийг мэдээлээгүй, 33,253.6 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроосон,
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалтын мэдээллийг мэдээлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх 77,716.4 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу [tender.gov.mn](http://tender.gov.mn)-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй учраас Ундрах тум ХХК, Алтан тариа ХХК, Цахим ертөнц ХХК, иргэн Цэсэм ХХК, Л. Өлзийсайхан, С.Энхтайван нартай шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023

оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус сургуулийн 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн орлого дутуу төвлөрүүлсэн, худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүдийг арилгаж, өр төлбөр үүсгэсэн зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 4. Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                 | Биелэлт  |              |      |
|-----------------|------------------------|-----------------|----------|--------------|------|
|                 | Тоо                    | Дүн             | Тоо      | Дүн          | Хувь |
| Акт             | 3                      | 1,639.4         | 2        | 487.3        | 30.0 |
| Албан шаардлага | 2                      | 8,572.4         | 1        | 422.5        | 50.0 |
| <b>Нийт дүн</b> | <b>5</b>               | <b>10,211.8</b> | <b>3</b> | <b>909.8</b> |      |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 46,747.7 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг 46,460.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Өр төлбөр дансны үлдэгдлийг 149.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлогыг 137.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,  
СНАГ-2024/197/НА-СТА-ТШЗ

баримтална”, 5.1.4 дэх “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”: 14.4.3.бүх өр төлбөр”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аудитаар нийт 149.5 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

### 5.1 Албан шаардлага

Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас хүнсний материалын 149.5 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоо, гүйлгээг гарахаас өмнө нь хянан баталгаажуулж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, өр төлбөрийг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга  | Нийт алдаа |                 | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |                 | /мянган төгрөгөөр/ |                 |              |  | Зөвлөмж |     |
|--|------------|-----------------|-----------------------------------|-----|--------------------------|-----------------|--------------------|-----------------|--------------|--|---------|-----|
|  |            |                 |                                   |     |                          |                 | Үүнээс             |                 |              |  |         |     |
|  | Тоо        | Дүн             | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн             | Залруулсан         |                 | Залруулаагүй |  | Тоо     | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг дутуу тайлагнасан. | 1          | 46,460.8        |                                   |     | 1                        | 46,460.8        | 1                  | 46,460.8        |              |  |         |     |
| Өр төлбөрийг дутуу тайлагнасан.                                | 1          | 149,5           |                                   |     | 1                        | 149,5           | 1                  | 149,5           |              |  |         |     |
| Бараа материалын орлогыг илүү тайлагнасан                      | 1          | 137,4           |                                   |     | 1                        | 137,4           | 1                  | 137,4           |              |  |         |     |
| <b>Дүн</b>   | <b>1</b>   | <b>46,747.7</b> |                                   |     | <b>1</b>                 | <b>46,747.7</b> | <b>1</b>           | <b>46,747.7</b> |              |  |         |     |

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил |              | Үүнээс        |     |                 |              |         |     |                                      |                     |   |     |
|--------------------|-------------|--------------|---------------|-----|-----------------|--------------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
|                    |             |              | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |              | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|                    | Тоо         | Дүн          | Тоо           | Дүн | Тоо             | Дүн          | Тоо     | Дүн | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн |
| Өр төлбөр үүсгэсэн | 1           | 149.5        |               |     | 1               | 149,5        |         |     |                                      |                     |   |     |
| <b>Дүн</b>         | <b>1</b>    | <b>149.5</b> |               |     | <b>1</b>        | <b>149,5</b> |         |     |                                      |                     |   |     |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |  |  |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--|--|
|  |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |  |  |
|  | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |  |  |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил             |             |     |               |     |                 |     |         |     |  |  |
| Шилэн дансанд мэдээлбэл зохих 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн | 1           |     |               |     | 1               |     |         |     |  |  |
| <b>Дүн</b>   | <b>1</b>    |     |               |     | <b>1</b>        |     |         |     |  |  |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                             |             |     |               |     |                 |     |         |     |  |  |
| <b>Дүн</b>   |             |     |               |     |                 |     |         |     |  |  |
| Нийт дүн   | 1           |     |               |     | 1               |     |         |     |  |  |